НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Нийслэлийн Онцгой байдлын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/269/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга<br>Ч.Болд<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn<br>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга<br>Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Я.Алтанцэцэг<br>Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ё.Лхагвадулам<br>Утас: 325093 Цахим хаяг: lkhagvadulamyo@audit.gov.mn<br>Аудитор: Б.Тэгшлхам<br>Утас: 325093 Цахим хаяг: tegshlkhamb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/148

танай ____________-ны № ____________-т

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА
Г.ГАЛБАДРАХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Онцгой байдлын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд тус газар нь үндсэн үйл ажиллагааны үр дүнд “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнагдсан байна. Дэвшилтэт технологийг нэвтрүүлж эрлийн үйл ажиллагаанд 4 дрон буюу нисэгчгүй нисдэг төхөөрөмжийг ашиглаж байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн шууд захирагч нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу систем мэдээлж, цахим дэлгүүрт захиалга өгсөн боловч худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй, үйл ажиллагааны чиглэлд нийцээгүй хуулийн этгээдээс худалдан авалт хийсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн хэрэгжилт 98.8 хувиар үнэлэгдэн, тайлагнасан байна.

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yasan bichig\2025.02.25 N OBG.docx 02023580

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.25.N.OBG.docx

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,760,476,755.59** | **4,098,457,391.16** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **227,637,091.00** | **13,830,490.00** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **227,637,091.00** | **13,830,490.00** |
| **3121** | **Төгрөг** | **227,637,091.00** | **13,830,490.00** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 227,637,091.00 | 13,830,490.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **3,532,839,664.59** | **4,084,626,901.16** |
| **351** | **Түүхий эд материал** | **1,599,881,676.39** | **2,131,006,224.69** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,481,065,320.30 | 2,012,860,468.60 |
| 35130 | Эм боох материал | 118,816,356.09 | 118,145,756.09 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 445,313,493.60 | 568,765,448.60 |
| **354** | **Хангамжийн материал** | **1,487,644,494.60** | **1,384,855,227.87** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 43,649,949.00 | 24,074,831.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 246,264,423.31 | 244,658,310.88 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 53,473,165.00 | 76,982,052.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 39,866,550.00 | 44,617,452.70 |
| 35450 | Барилгын засварын материал | 11,550.00 | 11,550.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,443,025.90 | 6,825.90 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,099,935,831.39 | 994,504,205.39 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **28,330,344,381.60** | **27,696,814,279.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **28,330,344,381.60** | **27,696,814,279.10** |
| **392** | **Биет хөрөнгө** | **27,783,346,396.50** | **27,149,816,294.00** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 24,893,736,967.00 | 24,893,736,967.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -555,963,773.81 | -1,209,648,265.05 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 3,827,379,106.00 | 4,063,950,218.88 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -2,679,159,578.48 | -2,946,407,510.61 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 2,706,504,670.12 | 3,183,875,170.12 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -2,039,454,549.35 | -2,210,775,238.69 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,105,976,545.84 | 1,117,176,245.84 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -506,782,978.80 | -602,401,567.35 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,059,576,607.00 | 1,059,576,607.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -28,466,619.02 | -199,266,333.14 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **546,997,985.10** | **546,997,985.10** |
| 39301 | Програм хангамж | 30,030,000.00 | 30,030,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -30,030,000.00 | -30,030,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 546,997,985.10 | 546,997,985.10 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **32,090,821,137.19** | **31,795,271,670.26** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **32,129,673.00** | **13,830,500.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **32,129,673.00** | **13,830,500.00** |
| **413** | **Өглөг** | **32,129,673.00** | **13,830,500.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **4136** | **Бусад өглөг** | **32,129,673.00** | **13,830,500.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 32,129,673.00 | 13,830,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **32,058,691,464.19** | **31,781,441,170.26** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **32,058,691,464.19** | **31,781,441,170.26** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,408,667,699.59 | 3,408,667,699.59 |
| 51101 | Өмч: - төрийн | 3,408,667,699.59 | 3,408,667,699.59 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **28,643,219,112.61** | **28,365,968,818.68** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 28,643,219,112.61 | 28,643,219,112.61 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -277,250,293.93 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 6,804,651.99 | 6,804,651.99 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **32,090,821,137.19** | **31,795,271,670.26** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **30,931,270,105.46** | **9,955,189,100.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **24,674,940,854.45** | **2,219,141,148.88** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **24,674,940,854.45** | **2,219,141,148.88** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,711,300,357.52 | 1,414,105,855.70 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 616,853,013.00 | 599,194,300.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,094,447,344.52 | 814,911,555.70 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ | 21,714,800,000.00 | 376,822,112.88 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ | 1,064,710,833.93 | 397,113,180.30 |
| 120009 | Бусад орлого | 184,129,663.00 | 31,100,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **6,256,329,251.01** | **7,736,047,952.02** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 4,796,113,600.00 | 6,257,236,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,796,113,600.00 | 6,257,236,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,460,215,651.01 | 1,478,811,652.02 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 321,215,410.00 | 208,356,720.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 178,761,000.00 | 98,721,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 960,239,241.01 | 1,171,733,432.02 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **7,997,182,039.06** | **10,232,439,394.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,225,625,896.06** | **9,954,221,308.93** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **7,051,174,078.27** | **9,512,878,617.59** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **4,753,872,326.51** | **6,426,351,164.00** |
| 210101 | Үндсэн цалин | 2,883,421,016.39 | 4,014,125,217.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,709,232,210.12 | 2,191,663,947.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 161,219,100.00 | 220,562,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **123,773,998.04** | **162,330,084.79** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,857,720.56 | 28,712,550.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,924,437.83 | 4,005,987.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,339,550.26 | 2,663,868.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 345,943.56 | 1,111,297.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 93,306,345.83 | 125,836,382.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **265,748,750.69** | **261,843,372.97** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 144,993,807.68 | 147,889,846.47 |
| 210302 | Түлш, халаалт | 101,352,573.20 | 90,216,447.95 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,402,369.81 | 23,737,078.55 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **204,359,526.30** | **458,930,106.89** |
| 210401 | Бичиг хэрэг | 23,600,861.00 | 53,325,441.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 145,094,225.00 | 137,878,117.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,570,725.78 | 8,571,491.66 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,400,000.00 | 3,010,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 21,693,714.52 | 26,503,980.90 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 229,641,076.33 |
| **2105** | **Нормативт зардал** | **287,325,298.30** | **216,297,983.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,571,899.20 | 9,029,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 106,152,913.10 | 207,043,683.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 175,600,486.00 | 224,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **90,526,770.00** | **132,811,961.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,485,600.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 84,041,170.00 | 132,811,961.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **176,604,878.53** | **226,781,972.26** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 150,159,490.00 | 211,059,415.26 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 10,743,367.53 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,522,072.00 | 3,115,567.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 1,144,000.00 | 1,144,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,221,000.00 | 6,750,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,814,949.00 | 4,712,990.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,148,962,529.90** | **1,627,531,972.68** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 494,100,722.00 | 183,228,222.30 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 33,750,600.00 | 85,632,335.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 621,111,207.90 | 1,358,671,415.38 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **174,451,817.79** | **441,342,691.34** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **118,755,000.00** | **116,342,490.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 35,900,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 82,855,000.00 | 116,342,490.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **55,696,817.79** | **325,000,201.34** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,696,817.79 | 325,000,201.34 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **771,556,143.00** | **278,218,085.90** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **771,556,143.00** | **278,218,085.90** |
| 223001 | Бусад хөрөнгө | 117,847,496.00 | 20,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **22,934,088,066.40** | **-277,250,293.93** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **9,951,362.50** | **00.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 9,951,362.50 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-9,951,362.50** | **00.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **22,924,136,703.90** | **-277,250,293.93** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **7,051,712,150.01** | **8,353,784,506.02** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **800,982,676.00** | **633,024,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **800,982,676.00** | **633,024,800.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **616,853,013.00** | **599,194,300.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 616,853,013.00 | 599,194,300.00 |
| 120009 | Бусад орлого | 184,129,663.00 | 33,830,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **6,250,729,474.01** | **7,720,759,706.02** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **4,796,113,600.00** | **6,257,236,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,796,113,600.00 | 6,257,236,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,454,615,874.01** | **1,463,523,406.02** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 321,215,410.00 | 208,356,720.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 178,761,000.00 | 98,721,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 954,639,464.01 | 1,156,445,186.02 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **6,686,346,231.01** | **8,251,261,734.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,686,346,231.01** | **8,251,261,734.02** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,494,214,413.22** | **7,799,227,932.68** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **4,049,651,899.57** | **5,266,442,000.00** |
| 210101 | Үндсэн цалин | 1,971,892,999.57 | 3,202,298,900.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,017,549,100.00 | 1,824,402,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 60,209,800.00 | 110,352,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 129,388,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **99,044,000.00** | **139,031,600.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,864,300.00 | 18,938,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,513,500.00 | 2,817,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,210,800.00 | 1,408,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 302,700.00 | 1,409,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 83,152,700.00 | 114,457,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **265,748,750.69** | **261,843,372.97** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 144,993,807.68 | 147,889,846.47 |
| 210302 | Түлш, халаалт | 101,352,573.20 | 90,216,447.95 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,402,369.81 | 23,737,078.55 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **86,581,680.53** | **21,293,291.66** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,531,100.00 | 5,500,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,570,725.78 | 8,571,491.66 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,400,000.00 | 3,010,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 56,630,854.75 | 4,211,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **78,799,299.20** | **165,608,837.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,295,199.20 | 6,084,750.00 |
| 210502 | Хоол, хүнс | 72,504,100.00 | 159,524,087.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **111,146,616.25** | **150,107,280.00** |
| 210604 | Урсгал засвар | 111,146,616.25 | 150,107,280.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,362,807,972.98** | **1,456,972,581.05** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,343,641,951.98 | 1,438,975,624.05 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,522,072.00 | 3,115,567.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 1,144,000.00 | 1,144,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,685,000.00 | 9,024,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,814,949.00 | 4,712,990.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **440,434,194.00** | **337,928,970.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 370,520,860.00 | 239,129,970.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 69,913,334.00 | 98,799,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **192,131,817.79** | **452,033,801.34** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **136,435,000.00** | **127,033,600.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 42,855,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 93,580,000.00 | 127,033,600.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **55,696,817.79** | **325,000,201.34** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,696,817.79 | 325,000,201.34 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **365,365,919.00** | **102,522,772.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **339,421,589.00** | **316,329,373.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **339,421,589.00** | **316,329,373.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **339,421,589.00** | **316,329,373.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 158,185,333.00 | 52,129,673.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 181,236,256.00 | 264,199,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-339,421,589.00** | **-316,329,373.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **25,944,330.00** | **-213,806,601.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **201,692,761.00** | **227,637,091.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **227,637,091.00** | **13,830,490.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,408,667,699.59** | **6,804,651.99** | **5,719,082,408.71** | **9,134,554,760.29** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 22,924,136,703.90 | 22,924,136,703.90 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,408,667,699.59** | **6,804,651.99** | **28,643,219,112.61** | **32,058,691,464.19** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -277,250,293.93 | -277,250,293.93 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,408,667,699.59** | **6,804,651.99** | **28,365,968,818.68** | **31,781,441,170.26** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,856,430,600.00** | **6,779,393,454.63** | **77,037,145.37** | **98.9** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,856,430,600.00** | **6,779,393,454.63** | **77,037,145.37** | **98.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,739,397,000.00** | **6,662,359,854.63** | **77,037,145.37** | **98.9** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **5,266,442,000.00** | **5,266,442,000.00** | **-** | **100.0** |
| 210101 | Үндсэн цалин | 3,202,298,900.00 | 3,202,298,900.00 | - | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 1,824,402,700.00 | 1,824,402,700.00 | - | 100.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 110,352,000.00 | 110,352,000.00 | - | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 129,388,400.00 | 129,388,400.00 | - | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **139,031,600.00** | **139,031,600.00** | **-** | **100.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,938,400.00 | 18,938,400.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,817,800.00 | 2,817,800.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,408,900.00 | 1,408,900.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,409,000.00 | 1,409,000.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 114,457,500.00 | 114,457,500.00 | - | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **337,348,200.00** | **261,843,372.97** | **75,504,827.03** | **77.6** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 199,258,200.00 | 147,889,846.47 | 51,368,353.53 | 74.2 |
| 210302 | Түлш, халаалт | 115,830,000.00 | 90,216,447.95 | 25,613,552.05 | 77.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,260,000.00 | 23,737,078.55 | (1,477,078.55) | 106.6 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **20,094,400.00** | **20,093,291.66** | **1,108.34** | **100.0** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,500,100.00 | 5,500,100.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,571,500.00 | 8,571,491.66 | 8.34 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,011,100.00 | 3,010,000.00 | 1,100.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,011,700.00 | 3,011,700.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **156,369,600.00** | **156,368,837.00** | **763.00** | **100.0** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,085,200.00 | 6,084,750.00 | 450.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 150,284,400.00 | 150,284,087.00 | 313.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **131,850,000.00** | **131,849,980.00** | **20.00** | **100.0** |
| 210604 | Урсгал засвар | 131,850,000.00 | 131,849,980.00 | 20.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **632,347,700.00** | **630,817,273.00** | **1,530,427.00** | **99.8** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 612,841,300.00 | 612,820,316.00 | 20,984.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,522,600.00 | 3,115,567.00 | 407,033.00 | 88.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 1,144,000.00 | 1,144,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,024,400.00 | 9,024,400.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 5,815,400.00 | 4,712,990.00 | 1,102,410.00 | 81.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **55913500.00** | **55913500.00** | **-** | **100.0** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 55,913,500.00 | 55,913,500.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **117033600.00** | **117033600.00** | **-** | **100.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **117,033,600.00** | **117,033,600.00** | **-** | **100.0** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 117,033,600.00 | 117,033,600.00 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **6,856,430,600.00** | **6,779,393,454.63** | **77,037,145.37** | **98.9** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **6,257,236,300.00** | **6,180,199,154.63** | **77,037,145.37** | **98.8** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 6,257,236,300.00 | 6,180,199,154.63 | 77,037,145.37 | 98.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **599,194,300.00** | **599,194,300.00** | **-** | **100.0** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 599,194,300.00 | 599,194,300.00 | - | 100.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **00.00** | **227,637,091.00** | **(227,637,091.00)** | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **00.00** | **13,830,490.00** | **(13,830,490.00)** | **-** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **237** | **235** | **2** | **99.2** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 216 | 189 | 27 | 87.5 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 20 | 17 | 3 | 85.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00 | 28 | (28) | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,411,067,778.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,411,067,778.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,401,067,778.05** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,200,000.00** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,200,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **9,240,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | 9,240,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **22,457,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 22,457,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,086,155,308.05** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,086,155,308.05 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **282,015,470.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 239,129,970.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 42,885,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,000,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **10,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,411,067,778.05** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,411,067,778.05** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 208,356,720.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 98,721,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,103,989,558.05 |

## 3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 81,157.4 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс алдаа зөрчлийг арилгах 81,157.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 81,157.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 29,994.7 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

*5.1.1 :* Бэлэн байдлын хүрээнд ээлжийн алба хаагчдын хоол хүнсний материалын худалдан авалтыг цахим системд нээлттэй тендер зарлаагүй, 35,027.4 мянган төгрөгийн хүнсний материал шууд худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д "*Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно*" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*”, “*эрх ба үүрэг*” батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

*5.1.2 :* Тайлант оны 1-4 дүгээр сард үйл ажиллагааны чиглэл зөрүүтэй хуулийн этгээдээс 46,130.0 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д "*Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно*", гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*”, “*эрх ба үүрэг*” батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны чиглэлд нийцсэн байгууллагыг судалж, төсвийн хөрөнгөөр бараа худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт :* Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй 2,006,589.5 мянган төгрөгийн 114 нэр төрлийн 402 хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон дахин үнэлгээ хийгээгүй байна.

Энэ нь УСНББОУС 17 “*Үндсэн хөрөнгө*” стандарт болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 3.1.2-д *"илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”,* ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 7 дугаар зүйлийн 7.1-д *"Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн ... эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж, шийдвэрлүүлнэ"* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэлгээ”, “нийцсэн бөгөөд зохистой” байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн жагсаалтыг бэлтгэн холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бэлэн байдлын хүрээнд ээлжийн алба хаагчдын хоол хүнсний материалын худалдан авалтыг цахим системд нээлттэй тендер зарлаагүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, бусад этгээдээс хүнсний материал худалдан авсан байна. | 1 | 35,07.4 | | | 1 | 35,07.4 | | | | | | |
| үйл ажиллагааны чиглэл зөрүүтэй хуулийн этгээдээс хүнсний материал худалдан авсан байна. | 1 | 46,130.0 | | | 1 | 46,130.0 | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй 2,006,589.5 мянган төгрөгийн 114 нэр төрлийн 402 хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон дахин үнэлгээ хийгээгүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **3** | **81,157.4** | | | **2** | **81,157.4** | **1** | **0** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төсвийн шууд захирагч нь цахим дэлгүүрт захиалга хүсэлт хүргүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. | 1 | 153,239.9 | | | | | 1 | 153,239.9 |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг www.tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлэл байршуулаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Нийт дүн** | **2** | **153,239.9** | | | | | **2** | **153,239.9** |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 22/A0270181 Улаанбаатар хот

НТАГ-2025/269/НА-СТА-ТШЗ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Онцгой байдлын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Бэлэн байдлын хүрээнд ээлжийн алба хаагчдын хоол хүнсний материалын худалдан авалтыг цахим системд нээлттэй тендер зарлаагүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, бусад этгээдээс 35,027,400.00 (*гучин таван сая хорин долоон мянга дөрвөн зуу*) төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Энэ нь УСНББОУС-30 "Санхүүгийн хэрэглүүр: тодруулга" болон MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4-д "*Голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх*", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д "*Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно*" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19 дүгээр зүйлийн 19.2-т "*Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана*" заалт, 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;*", 4.2.1.11-д " *хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал* " заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төсвийн хөрөнгөөр хийж байгаа худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж, системд захиалга хүргүүлж, цахим дэлгүүрээс худалдан авалт хийж байх, аудитын хэрэгжилтийг 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга (Г.Галбадрах), ахлах нягтлан бодогч (Д.Урантулга) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН**[1]**:**

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043261

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 23/А0270181 Улаанбаатар хот
НТАГ-2025/269/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Онцгой байдлын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант оны үйл ажиллагааны чиглэл зөрүүтэй хуулийн этгээдээс 46,130,000.00 төгрөгийн (*дөчин зургаан сая нэг зуун гучин мянга*) хүнсний материал худалдан авсан байна.

Энэ нь УСНББОУС-30 "Санхүүгийн хэрэглүүр: тодруулга" болон MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4-д "*Голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх*", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д "*Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.-д "*үнэн зөв байх*" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19 дүгээр зүйлийн 19.2-т "*Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана*" заалт, 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;*", 4.2.1.11-д " *хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал* " заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Үйл ажиллагааны чиглэл зөрүүтэй хуулийн этгээдээс бараа ажил үйлчилгээ худалдан авахгүй байх, аудитын хэрэгжилтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга Г.Галбадрах, ахлах нягтлан бодогч Д.Урантулга нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:**

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043263